



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

#11

(20)

Сар тутмын хэвлэл

<http://www.mnier.mn>

XI сар

Стратеги төлөвлөгөө
(Нүүр 1-3)



Монгол улс ПИСА 2022
(Нүүр 5-9)



Үйл явдал, мэдээ
Нүүр (15-16)



Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэнгийн 2023-2027 оны стратеги төлөвлөгөө батлагдлаа



Бид Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, үнэ цэнийг өндөржүүлэх, судалгааны байгууллагаас хэрэгжүүлэх үйл ажиллагааны бодлого, чиглэл, төлөвлөлтийг сайжруулах, улам илүү чанаржуулах зорилгоор байгууллагын стратеги төлөвлөгөө (2023-2027)-г боловсрууллаа.

Ингэхдээ “Боловсролын хүрээлэнгийн стратегийн төлөвлөгөө 2018-2022”-ний хэрэгжилтэд үнэлгээ хийж, туршлага, сургамжийг үндэслэн дөрвөн үе шаттайгаар зохион байгууллаа. Үүнд:

I үе шат (өнөөгийн байдлын): байгууллагын чадамжийн шинжилгээ, стратегийн бэлэн байдлын шинжилгээ, асуудлын шинжилгээ хийж эхний төлөв байдлыг тодорхойлсон.

II үе шат (системийн шинжилгээ): макро орчны бодлогын, эрх зүйн, хүн ам зүйн, нийгэм соёлын, технологийн судалгаа; микро орчны хэрэглэгч, хамтрагч, дэмжигчийн судалгаа хийж SWOT, MECSON, CROSS шинжилгээ хийсэн.


III үе шат (стратеги төлөвлөгөөний эхний хувилбар): Дээрх шинжилгээнд суурилан эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс, баримтлах зарчмаа тодорхойлон, хүрээлэнгийн хөгжлийн зорилго, зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөг томъёолж, нийт ЭША, албан хаагчдаас хэлэлцүүлж, санал авч тусгасан.

IV үе шат (стратеги төлөвлөгөөний нарийвчилсан хувилбар): Хөгжлийн замын зураг, хамтын ажиллагааны төлөвлөгөө, стратеги хэрэгжүүлэх шалгуур үзүүлэлт, хариуцах эзэн, хугацаа, өртөг зардал, менежментийг баг томилж сайжруулалт хийсэн.

БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ТЭМҮҮЛЭЛ

АЛСЫН ХАРАА: БИДНИЙ АЛСЫН ХАРАА: Боловсролыг сайн сайхан нийгэм рүү хөтлөх судалгааны хүрээлэн байна.

1. БИДНИЙ ФИЛОСОФИ



2. БИДНИЙ ХАНДЛАГА:



Алсын зорилго үгүй бол ойрын зовлон эхэлнэ.

Сэтгэлдээ багтааж чадвал их багын ялгаагүй.

Хорвоогийн бүх өнгө хоёр чавхдаст багтана.



Менежмент

Дижитал ертөнц

Системийн онол



Хэмжихгүй бол удирдахгүй. Байгууллагын соёл нь эрхэм зорилго..

Сэтгэдэг систем



Key Performance Indicator (KPI)

Objective Key Result (OKR)

Draw your system Before your think.

3. БИДНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН:

Систем			
Нэр	Статик (Static)	Динамик (Dynamic)	Фрактал (fractal)
Бүтэц	Эрдэм {хэрэв \square, Δ^2 бол \square } Мэдлэг { $\square - \Delta^2$ $\square \Delta = \square$ } Мэдээлэл { $\square \Delta \square \square$ } Өгөгдөл { \dots }		
Чанар	Агуулга Үл хөдлөх	Хугацаа Амьсгалдаг	Код Төгс

Бодлого, төлөвлөлтийн болон боловсролын онол, арга зүйн үндэс, Монгол Улсын хөгжлийн бодлогын зорилт болон боловсролын салбарын эрх зүйн зохицуулалт мөн “Боловсролын хүрээлэнгийн стратегийн төлөвлөгөө 2018-2022”-ний хэрэгжилт, туршлага, сургамжийг үндэслэн БСҮХ-ийн 2023-2027 онд баримтлах Эрхэм зорилго, үнэт зүйл, зарчмыг тодорхойлов.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол улсын боловсролын хөгжлийн шинжлэх ухааны үндэслэлийг тодорхойлж, Монгол хүний хөгжилд хувь нэмэр оруулна.

ҮНЭТ ЗҮЙЛ

ЧАНАРТАЙ СУДАЛГАА

- Боловсролын хөгжлийн асуудлаар шинжлэх ухааны суурь болон хавсарга судалгаа

СУДАЛГААНЫ УР ЧАДВАР, ЧАДАВХ

- Үндэсний хэмжээнд судалгаа хийх чадвар, зах зээлд өрсөлдөх, улмаар тэргүүлэх чадвар

ТУРШЛАГА

- 60 жилийн хугацаанд тасралтгүй ажиллаж ирсэн арвин туршлага

ХҮМҮҮНЛЭГ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Олон Улсын түвшинд хамтран ажиллах чадвар, чадвар

МЭДЛЭГТ СУУРИЛСАН ШИНЖЛЭХ УХААНЧ ХАНДЛАГА

- Мэдээллийг боловсруулах, шинэ мэдлэг бүтээх суралцагч байгууллага

ЗАРЧИМ

ШИНЖЛЭХ УХААНЧ БАЙХ ЗАРЧИМ

- Орчин үеийн шинжлэх ухааны үзэл баримтлал, арга зүйг хэрэглэх;
- Судалгаа баталгаа, нотолгоотой байх;
- Бүтээл үр өгөөжтэй байх;

ХҮМҮҮНЛЭГ БАЙХ ЗАРЧИМ

- Хувь хүний болон хамт олны хүсэл эрмэлзлийг хүндэтгэх;
- Эрдэм, судалгааны академик эрх чөлөө, ёс зүйг дээдлэх;
- Бүтээгдэхүүн нь хүний болон байгаль, нийгмийн сайн сайханд зориулагдсан байх;

ЧАНАРТАЙ, ҮР АШИГТАЙ БАЙХ ЗАРЧИМ

- Үйл ажиллагаа, бүтээгдэхүүн нь боловсролын үйлчилгээний чанарын шаардлагыг хангах;
- Боловсрол, сургалтын судалгаа арга зүйгээр боловсролын салбарын бүх шатны ажилтнуудад үйлчлэх;
- Боловсролын судалгааны мэдээллийг олон нийтэд түгээх, сурталчлах;

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн 2023-2027 оны стратеги төлөвлөгөөний зорилго, зорилтууд

БСҮХ-ийн эрхэм зорилго, үнэт зүйлсийг үндэслэн 2023-2027 онд стратегийн зургаан зорилгын хүрээнд 19 зорилт дэвшүүлсэн болно.



Стратегийн зорилгын хүрээнд тодорхойлсон 19 зорилтыг хэрэгжүүлэх гол үйл ажиллагааг энэхүү төлөвлөгөөний “Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүн” хэсэгт авч үзсэн болно.

1. ЭРДЭМ СУДЛАЛД ТҮҮЧЭЭЛЭГЧ

Бид боловсролын судалгааны амжилт гаргана.

- 1.1 Үндэсний нэгдмэл үнэт зүйлтэй, соёлын дархлаатай Монгол хүний хөгжилд боловсролын оруулах хувь нэмрийг тодорхойлно.
- 1.2 Боловсролын судалгааны жишиг стандарт (шаардлага) -ыг бий болгоно.
- 1.3 БСҮХ-ийн судалгааны тэргүүлэх чиглэлээр боловсролын салбарын бодлогын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, судалгааны үр нөлөөг нэмэгдүүлнэ.
- 1.4 БСҮХ-ийн чадавхыг бэхжүүлнэ.

2. БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫГ ЭРХЭМЛЭГЧ

Бид боловсролын хүртээмж, чанар, үр ашгийг дэмжих болно.

- 2.1. Боловсролын бүх түвшний сургалтын хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлнэ.
- 2.2. Бүх түвшний мэдээллийн технологийн сургалтын хөтөлбөрийг сайжруулж агуулгыг шинэчлэн боловсруулна.
- 2.3. Багшийн чадамжийн хүрээ тодорхойлох замаар боловсролын бүх түвшний багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжинэ.
- 2.4. Боловсролын хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр бүх шатны боловсролын байгууллагад дэмжлэг үзүүлнэ.

3. ЁС ЗҮЙТЭЙ ТҮНШЛЭГЧ

Бид дотоод, гадаад хамтын ажиллагааны хариуцлагатай, найдвартай хамтрагч байна.

- 3.1. Олон улс болон үндэсний судалгааны байгууллагуудтай боловсролын судалгааны чиглэлээр харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- 3.2. Боловсролын судалгааны арга зүйг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр үндэсний болон орон нутгийн боловсролын байгууллага, сургуулиудтай хамтран ажиллана.
- 3.3. Боловсролын салбарт салбар дундын хамтарсан судалгааг хөгжүүлнэ.

4. ШИНИЙГ САНААЧЛАГЧ

Бид шинэ санаа, инновацт бүтээл, дижитал технологийг дэмжинэ.

- 4.1. Шинэ санаа, бүтээл, инновац хөгжүүлэх менежментийг бүрдүүлнэ.
- 4.2. Цахим суралцахуйн арга зүйг хөгжүүлнэ.
- 4.3. Шинэ технологийг аюулгүй нэвтрүүлэх замаар байгууллагын үйл ажиллагааг оновчтой болгоно.

5. ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭГЧ

Бид бүх түвшинд хүний нөөцийг чадавхжуулна.

- 5.1. БСҮХ-ийн хүний нөөцийн хөгжлийг дэмжинэ.
- 5.2. Үндэсний түвшинд боловсрол судлаачдын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулна.

6. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИГЧ

Бид тогтвортой хөгжлийн үзэл санааг хөгжүүлнэ.

- 6.1. Тогтвортой хөгжлийн үзэл санааг үйл ажиллагаандаа тусгана
- 6.2. Тогтвортой хөгжлийг дэмжигч байгууллага болно.

EDUTEN ПЛАТФОРМ



Eduten платформ нь хүүхдүүд математикт айдасгүйгээр, аз жаргалтайгаар суралцахад нь дэмжлэг болох зорилготой платформ юм. Өөрөөр хэлбэл тоглоомын арга зүйд суурилан боловсруулсан дасгал, даалгавар бүхий, хиймэл оюун ашиглан сурагчдын суралцахуйг дэмжих, багш нарын ажлын ачааллыг бууруулах, математикийн хичээлийн чанар, үр өгөөжийг дээшлүүлэх ач холбогдолтой ухаалаг систем, сургалтын цахим хэрэглэгдэхүүн юм.




Энэхүү сургалтыг дэмжих системийг Финландын Турку их сургуулийн эрдэмтэд 18 жилийн туршилт судалгаанд үндэслэн бүтээсэн бөгөөд өдөр, цаг минут тутамд тасралтгүй боловсронгуй болгон хөгжүүлсээр байна. Сургалтын онол, арга зүй, технологийг хиймэл оюун, МХХТ-той хослуулан хөгжүүлсэн энэхүү сургалтын шинэ арга зүй, технологийг дэлхийн 50 гаруйн оронд сургалтад ашиглаж байна. ЮНЕСКО-ийн хиймэл оюун ухаанаар дамжуулж боловсролыг дэмжих шилдэг туршлагыг нэвтрүүлсэн бүтээлд олгодог “Боловсролын төлөө ICT”. 2020 он, ЮНИСЕФ-ийн “Онцлох Edtech”. 2022 он шагналуудыг тус тус хүртсэн байна.

EDUTEN ОНЦЛОГ ДАВУУ ТАЛУУД



Хүүхэд, тэр дундаа бага насны хүүхэд тоглож байхдаа илүү төвлөрч, суралцангаа хөгждөг онцлогийг харгалзан математикийн дасгал даалгавруудыг мэдээллийн технологи ашиглан тоглоом хэлбэрт хувирган тодорхой арга зүй, зааварчилгааны дагуу сургалтад хэрэглэн хүүхдийн математик ур чадварыг хөгжүүлдэг.

Хиймэл оюун (AI)-аар сурагчдын гүйцэтгэлийн мэдээлэлд байнгын боловсруулалт хийж, сурагчдын суралцахуйн ахиц, амжилт, идэвх, оролцооны тухай мэдээллийг сурагч бүрээр болон сурлагын амжилтаар нь богино хугацаанд эрэмбэлэн бүлэглэдэг бөгөөд энэ нь багш, сургуулийн удирлага, орон нутгийн мэргэжилтнүүдэд сургалтыг удирдан чиглүүлэх, үнэлэх, хяналт тавих боломжийг олгодог.




Багшийн сургалтын хэрэглэгдэхүүн (ТӨМ, ажлын хуудас, .. г.м) боловсруулах, дэвтэр засах, сурагчдын суралцахуйн үр дүнг үнэлэх, нэгтгэж анализ, дүгнэлт хийх зэрэг ажлыг хиймэл оюунаар хялбархан шийдсэнээр багшийн ажлын ачаалал багасах, улмаар аналитик мэдээллийг ашиглан хичээлийнхээ үр дүнг цаг тухайд нь үнэлэх, хянах, сурагч нэг бүрт тохирсон дасгал даалгавар өгөх, сурагчдаа урамшуулах зэргээр хичээл, сургалтаа чанаржуулж, сургалтын чанарт ахиц гарах боломж бий болж байгаагаараа сургалтын арга зүй, технологийн хувьд ач холбогдолтой.

Математикийн хичээлийн үндэсний хөтөлбөрийн агуулгад баримжаалан анги тус бүрд тохирсон жишиг курс (нэг ангийн жилийн агуулгад харгалзах дасгал даалгавруудыг сэдвээр нь ангилан байршуулсан багц)-үүдийг агуулгын залгамж, дасгал даалгаврын давтамжийг тохируулан байршуулсан байдаг ба багш сурагчдын түвшинд тохирсон дасгал, даалгавруудыг нээж ажиллуулах боломжийг олгодог.



EduTen платформын даалгаврын санг ашиглан багш өөрийн хүссэн агуулга, багтаамж бүхий хичээл, курс үүсгэх, шалгалтын сэдэв боловсруулах, дасгал даалгавруудыг сайжруулах, хөгжүүлэх санал өгөх боломжтой төдийгүй мэргэжилтнүүд үндэсний онцлогт тохирсон шинэ контентоор баяжуулах, хуучин дасгал даалгавруудыг хувирган өөрчлөх, тохиромжгүй даалгавруудыг устгах, бусад улс орны даалгавруудаар баяжуулах бүрэн боломжтой. Өөрөөр хэлбэл EduTen платформ нь багш өөрөө тохируулан хэрэглэх, тасралтгүй шинэчлэн хөгжүүлэх боломжтой ухаалаг систем юм.

EDUTEN МОНГОЛД



Шинжлэх ухаан, технологийн хурдацтай хөгжил нь боловсролын үйлчилгээг хүргэх арга хэрэгсэл, агуулгыг дахин эргэн харах, технологийн давуу талыг үр дүнтэйгээр ашиглах хэрэгцээ, шаардлагыг бий болгож, дэлхийн улс орнуудын дунд EdTech-ийг хөгжүүлэх чиглэлд хүчтэй өрсөлдөөн бий болоод байна. Нийгэм, хувь хүний хөгжил, хэрэгцээ ч үүнийг хүлээж, шаардаж байна.

Энэхүү зайлшгүй хэрэгцээ, шаардлагыг хангах чиглэлд Монгол улс бодлогын түвшинд өндөр ач холбогдол өгч “Алсын хараа-2050 Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого”, “Боловсролын салбарын хөгжлийн дунд

хугацааны төлөвлөгөө 2021-2030” гэх мэт бичиг баримтуудад боловсролын салбарт үр дүнтэй, үр ашигтай, ирээдүйгээ харсан цахим шилжилтийг хийх, түүнд чиглэсэн бодлого хэрэгжүүлэх, боловсролын чанарыг ахиулах тодорхой

зорилтуудыг дэвшүүлсэн байдаг. Эдгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй ажлуудын нэг Eduten платформыг турших, туршилт үр дүнд үндэслэн үндэсний хэмжээнд нэвтрүүлэх ажил юм.

ТУРШИЛТ СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн 2022-2023 оны хичээлийн жилийн 2, 3-р улиралд Eduten платформын сургалтын үр дүнд үзүүлж буй үр, нөлөөг тодорхойлох, энэ төрлийн платформыг сургалтад нэвтрүүлэхэд орчны болон хүний нөөц, сурагч, эцэг эх, багшийн бэлэн байдал, үүсэх эерэг болон сөрөг нөлөөг үнэлэх зорилготой туршилт судалгааг хийсэн. Туршилт судалгаанд нийслэл, аймаг, сумын 9 сургуулийн 15 бүлгийн багш нар удирдах ажилтнууд, 520 сурагч хамрагдсан.



Туршилтын үр дүнгээс харахад оролцсон сурагчид (eduten платформыг сургалтад ашигласан)-ын математик ур чадвар ойролцоогоор 21 хувийн ахицтай байсан ба энэ нь хяналтын бүлгийн сурагчид (eduten платформыг сургалтад хэрэглээгүй уламжлалт байдлаар хичээллэсэн) -ын ахицаас ойролцоогоор 4 хувиар илүү байв. Энэ нь тухайн платформ сурагчдын математик ур чадварын хөгжилд эерэг нөлөө үзүүлж байгааг харуулж байна.



Туршилтад хамрагдсан сурагчдын 98.5%, эцэг эхийн 89.7%, багш нарын 86.6%, удирдах ажилтнуудын 90.5% нь Eduten Платформ математикийн сургалтын чанарыг сайжруулахад бодит дэмжлэг болж байна гэж туршилт дараах судалгаанд хариулсан.


Эндээс сурагч, эцэг эх, сургуулийн удирдлагын сэтгэл ханамж сайн байсан ба энэхүү платформыг цаашид сургалтад ашиглах өндөр хүлээлттэй байна.

Тэр дундаа сурагчдын сурах хүсэл эрмэлзэл нэмэгдэж, математикийн хичээлд сонирхолтой болсон нь туршилтын үр дүнгээс харагдсан. Багш нарын 86.7%, удирдах ажилтны 90.5%, эцэг эхийн 94.3%, сурагчдын 96.4% нь математикийн хичээлийг сонирхон судлах хүсэл эрмэлзэл нэмэгдсэн гэж үзсэн байна.



Энэхүү платформ нь багшийн ачааллыг бууруулахад бодитой дэмжлэг үзүүлж байсан (багш нарын 80% нь, удирдах ажилтны 81% нь багшийн ачааллыг бууруулж байна гэж үзсэн) ба багш нарын хувьд тус платформыг цаашид сургалтад ашиглах хүсэл эрмэлзэл, хүлээлт өндөр байна (100%).

Сургуулийн удирдлагуудын цахим ур чадвар харилцан адилгүй ч платформыг хүлээж авч байгаа хандлага эерэг (91% нь сургалтын үйл явцыг удирдах, хянахад дэмжлэг болж байна гэж үзсэн), цаашид сургалтад нэвтрүүлэхийг 100% дэмжиж байна.



Эцэг эхчүүдийн платформын туршилтад сэтгэл хангалуун байсан ба судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 90% нь МХХТ-ийг сургалтад ашиглах нь үр дүнтэй, тус платформыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсэн.

ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙ

Туршилт судалгааны үр дүнд үндсэлэн БШУЯ үндэсний хэмжээнд Eduten платформыг нэвтрүүлэх нь зүйтэй гэсэн шийдвэрийг гаргасан ба 2023-2024 оны хичээлийн жилийн 2-р улирлаас 3, 4-р ангид, 2024-2025 оны хичээлийн жилээс 1-5-р ангиудад үе шаттайгаар нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Үндэсний хэмжээнд нэвтрүүлэх ажлыг Боловсролын ерөнхий газар хариуцан зохион байгуулж байна. Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн 1-5-р ангийн бүх агуулгыг орчуулах, үндэсний хөтөлбөртэй нийцүүлэх, дасгал даалгаврын агуулга, контекстийг үндэсний онцлогтоо тохируулан хөрвүүлэх ажлыг хариуцан ажиллаж байна.

Үндэсний хэмжээнд нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд багш нарыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах, орчны бэлтгэлийг хангах гэх мэт ажлууд хийгдсэн ба багш нар хэрэглэнгээ суралцаж байгаа ба хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилготой мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл оролцсон үндэсний дэмжих баг (6 хүнтэй), дэмжигч багш нарын баг (1000 багш) өдөр тутмын үйл ажиллагаанд тулгарсан асуудлыг шийдэх, цахим хэрэглэгдэхүүнийг үр дүнтэй ашиглахад арга зүй, техникийн дэмжлэгийг өгөн ажиллаж байна.

Хэрэгжилтийн явцаас харахад Eduten платформыг сургалтад амжилттай үр дүнтэй ашиглахад боловсролын шат шатны байгууллагын удирдлага, холбогдох мэргэжилтэн, багш нар хариуцлагатай уялдаа холбоотой ажиллаж, сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлж чадвар математикийн хичээлийн сургалтын чанарыг ахиулахад өндөр үр өгөөж өгөх бүрэн боломжтой юм.

Сингапур улсад зохион байгуулагдсан “Edutech Asia Expo”-д оролцов

Найм дахь удаагийн “Edutech Asia Expo” 2023 оны 11-р сарын 7-9-ний өдрүүдэд Сингапур улсад зохион байгуулагдав. Энэ жилийн экспод 400 гаруй илтгэгч, 120 орчим EdTech үйлчилгээ үзүүлэгч, 42 энэ төрлийн гарааны бизнес эрхлэгчид хуран чуулж, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулж, сурталчилсан. Монгол Улсаас **БШУЯ, БСҮХ, БЕГ, БҮТ, БМТТ, “Medle”** цахим сургуулийн төлөөлөл оролцов.

Салбартаа тэргүүлэгч **Lenovo, Microsoft, ClassIn, Intel, Google** гэх мэт компаниуд дэлхийн боловсролын дижитал өөрчлөлтийг тодорхойлоход туслах хамгийн сүүлийн үеийн технологиудыг танилцуулав.



Энэ өдрүүдэд Lenovo-ийн Эдди Анг, Microsoft-ын Ларри Нелсон, Нээлттэй Их Сургуулийн доктор Барт Риентис, Educate Ventures Research-ийн доктор Роуз Лаккин, Intel-ийн Одри Лим, Доктор Бронвин Стүки зэрэг салбартаа тэргүүлэгч оюун ухаантнуудаар удирдуулсан үндсэн хуралдаанууд явагдсан юм.

**Эдди Анг****Ларри
Нелсон****Барт
Риентис****Роуз Лаккин****Одри Лим****Бронвин
Стүки**

Тус үйл ажиллагааны хоёр дахь өдөр өнгөрсөн жилийн бодлогын үндсэн хэлэлцүүлгийн амжилтыг үндэслэн EDUtech Азийн бодлогын дээд хэмжээний уулзалтыг эхлүүлснээр хуралдааны цар хүрээг улам баяжуулах боломжоор хангасан. Хуралдаанд Азийн боловсролын яамд болон Засгийн газрын агентлагуудын төлөөлөгчид олон чухал сэдвүүдийг хамарсан хэлэлцүүлэг өрнүүлэв. Хэлэлцүүлэгт Засгийн газрын технологийн шинэчлэл, ажиллах хүчийг дижитал ур чадвараар бэхжүүлэх, дижитал боловсролын тогтвортой байдал, хиймэл оюун ухааны зохицуулалт, мэргэжлийн боловсролын ач холбогдол зэрэг багтсан юм.

“Edutech Asia Expo”-д оролцогч Азийн улс орнуудын Edtech компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээтэй танилцахад дараах ерөнхий чиг хандлага ажиглагдав.

Сургалтын хөтөлбөр, сурах бичгийн тухайд:

Компьютерын ухаан, STEM зэрэг хичээлүүдийн хөтөлбөр нэлээд интеграци шинжтэй болох төлөвтэй байна. Бүтээмэл оюун, кодчилал ба роботыг хослуулах байдлаар сурагчдын компьютерын ухаан, STEM чадварыг хөгжүүлэх хөтөлбөрүүд нэлээд өргөжих хандлагатай байна. Сурах бичиг бүтцийн хувьд мөн нэлээд өөрчлөгдөж байна. Ялангуяа сурагчийн номны дасгал, суралцахуйн үйл ажиллагааны тавил илүү уян хатан болохын зэрэгцээ, технологи, хэрэглэгдэхүүнтэй шууд холбох боломжтой болжээ.

Сургалтын орчин, хэрэглэгдэхүүний тухайд:

Edtech компаниуд сургалтын орчныг илүү уян хатан болгох, ингэхдээ цахим болон холимог сургалт зохион байгуулах платформ, дэмжих технологи, хэрэглэгдэхүүнийг илүү хүчирхэг болгож байна. Тухайлбал үүлэн технологид суурилсан сургуулийн цахим аюулгүй байдлын систем, мэдээллийн технологийн менежментийг цогцоор нь шийдэх хүчирхэг дэд бүтцийг бий болгож байгаа ажээ. Түүнчлэн сургалтын үйл ажиллагаанд проектын хэрэглээ багасах төлөвтэй болж байна. Энэ орон зайг ухаалаг самбар, TV эзлэх дүр зураг харагдаж байна. Тухайлбал үзэсгэлэнд хүрэлцэн ирсэн 1 edtech компанитай уулзахад тухайн ганц компани Японы ЕБС-ийн 10-15 хувийг ухаалаг самбар, TV-ээр хангаж байна. Мөн ухаалаг самбар, TV нь дан ганц проектр, дэлгэцийн үүргийг гүйцэтгээд зогсохгүй өөр дээрээ боловсролын контент, агуулгын сантай болж хөгжиж байна.

Суралцахуйн үнэлгээний тухайд:

Цахим технологийн шийдэл үнэлгээ зохион байгуулах үйл явцыг улам бүр хөнгөвчилж байна. Тухайлбал, задгай төрлийн даалгавар, эссэ бичлэгийн гүйцэтгэлийг оноожуулах ажлын ухаалаг үзэг, тусгай технологиор боловсруулсан цаасны тусламжтайгаар шууд засах, оноожуулах боломжтой болж байна.

ПИСА ГЭЖ ЮУ ВЭ?



ПИСА нь боловсролын бодлого, хэрэгжилтийн бодит үр дүнг тод томруунаар харуулдаг тасралтгүй шинж чанартай үнэлгээ бөгөөд улс, орнууд болон тэдгээрийн доторх харилцан адилгүй хүн ам зүйн дэд бүлгүүдэд харьяалагдах сурагчдын мэдлэг, ур чадвар эзэмших чиг хандлагыг судлах, үнэлэлт, дүгнэлт өгөхөд чухал үүрэг гүйцэтгэдэг юм.

Түүнчлэн улс, орнуудын бодлого боловсруулагчдад ПИСА-ийн үр дүнгээр дамжуулан өөрийн орны сурагчдын мэдлэг, ур чадварыг бусад орны сурагчидтай харьцуулан үнэлж, бусад орны боловсролын системд амжилттай нэвтрүүлсэн, хэмжигдэхүйц зорилтуудтай жин тэнцэхүйц бодлогын зорилтуудыг тодорхойлж, тэдгээрийн ололт амжилт, туршлагаас суралцах боломж бүрддэг.



ПИСА нь сурагчид мэдлэгийг дахин бүтээж чадаж байгаа эсэхийг үнэлээд зогсохгүй сурагчид сурсан зүйлсээ хэр сайн өөрийн болгон ашиглаж байгаа, тухайн мэдлэгээ сургууль болон сургуулиас гадуурх танил бус орчинд хэрэглэж чадаж байгаа эсэхийг үнэлдэг. Энэхүү хандлага нь хувь хүн мэддэг зүйлээрээ бус харин мэдлэгээ ашиглан хийж бүтээснээрээ орчин үеийн эдийн засгийн системээс ашиг, хувь хүртэх үзэл санаанд суурилж байгаа нь харагдах биз ээ.

ПИСА нь сурагч, сургуулийн удирдлагад зориулсан асуулга судалгаагаар сурагчдын гэр орны нөхцөл байдал, суралцахуйн хандлага болон сурах орчинтой холбоотой мэдээллийг цуглуулна.

Төрөл бүрийн асуулгаар цуглуулсан мэдээллийг нэгтгэсэн ПИСА үнэлгээ нь үндсэн гурван төрлийн үр дүнг харуулдаг. Үүнд:

- Сурагчдын мэдлэг, чадварын суурь түвшинг харуулсан үндсэн үзүүлэлтүүд;
- Холбогдох чадварууд нь хүн ам зүй, нийгэм, эдийн засаг, боловсролын янз бүрийн хувьсагчид болон боловсролын илүү өргөн хүрээний үр дүн, тухайлбал, сурлагын амжилт, сайн сайхан байдал зэрэгтэй хэрхэн холбогдож буйг харуулсан асуулга судалгааны үзүүлэлтүүд;
- ПИСА үнэлгээнд улс орон хоёр дахь удаагаа оролцсоноос эхлэн дундаж үр дүн, сурагчдын сорил хоорондын үр дүнгийн өөрчлөлт, сурагч, сургууль, системийн түвшний суурь хувьсагч болон үр дүнгийн хамаарлыг харуулсан ерөнхий чиг хандлагын үзүүлэлтүүд багтана.



ПИСА-ийн үндсэн чиглэл болох унших чадвар, байгалийн ухаан, математикийн сорилын гүйцэтгэлээр тооцсон дундаж оноонд үндэслэн оролцогч улс орнуудыг амжилтаар нь эрэмбэлдэг. Өөрөөр хэлбэл, дээрх 3 чиглэлийн нийлбэр оноо гэж гардаггүй бөгөөд тухайн чиглэл тус бүрээр сорилын оноонд үндэслэн улс, орнуудыг эрэмбэлдэг гэсэн үг юм.

Түүнчлэн ПИСА-ийн үр дүнг улс орнуудын боловсролын бодлого, практик хэрэгжилтэд тусгах боломжтой санал, зөвлөмжийг боловсруулах, сурагч, сургууль болон улс орнуудын талаарх олон талт мэдээллийг нэгтгэн цуглуулж тэдгээр мэдээллийг гүйцэтгэлийн ялгаатай байдлыг онцлон харуулах, өөр өөр нөхцөл байдалд амжилт үзүүлж буй сурагч, сургууль, боловсролын системүүдийн онцлогийг тодорхойлоход ашиглаж ирсэн билээ.

ПИСА (2022)-ИЙН ОНЦЛОГ



ПИСА (2022) үнэлгээнд 690 000 гаруй сурагч хамрагдсан бөгөөд эдгээр сурагч нь оролцогч 81 улс орны сургуульд суралцаж буй 29 сая орчим 15 настай сурагчдын төлөөлөл юм.

ПИСА (2022) нь математикийн сорилд илүүтэй ач холбогдол өгсөнөөрөө онцлог байсан бөгөөд унших чадвар, байгалийн ухааны сорилыг үнэлгээний дэд чиглэл болгосон билээ.

Математикийн мэдлэг, чадвар гэдэгт нь бодит ертөнцийн олон талт нөхцөл байдалд асуудлыг шийдвэрлэхийн тулд математик үндэслэл гаргах, томъёолох, ашиглах, тайлбарлах чадварыг хэлнэ (ЭЗХАХБ, 2023). Үүнд өөр хоорондоо уялдаатай гурван агуулга, ойлголтыг багтаасан байна.

ТАНИН МЭДЭХҮЙН ҮЙЛ ЯВЦ: Математикийн агуулгын мэдлэгийн эдгээр ангиллаар сурагчид учир шалтгаанд тулгуурлан, асуудлыг томъёолох (бодит ертөнцийн нөхцөл байдлыг математик асуудлын нөхцөлдүүлэг болгон хувиргах замаар), нэгэнт томъёолсон математикийн асуудлыг шийдвэрлэх, шийдлийг тайлбарлаж, үнэлэх үйл явц юм. ПИСА (2022)-ийн хувьд математик учир шалтгааныг танин мэдэхүйн үйл байдлаар тусад нь оруулсан хэдий ч энэ нь ПИСА-ийн математикийн сорилын тухайд цоо шинэ ойлголт биш юм. Дедуктив болон индуктив үндэслэлийг багтаасан математик учир шалтгаан нь асуудал шийдвэрлэх загварын үндсэн элемент байсаар ирсэн бөгөөд математикийн цөм мэдлэгтэй байхыг шаарддаг. Энэхүү зарим цөм ойлголт, мэдлэг нь сургуулийн математикийн хичээлд агуулагддагийг дурдах нь зүйтэй. Дээрх цөм ойлголтуудад: тоо хэмжээ, тооны систем, тэдгээрийн алгебр шинж чанарын ойлголт; хийсвэрлэл, дүрс, тэмдэгтийн илэрхийлэл; математик бүтэц, тэдгээрийн зүй тогтол; тоо хэмжээ хоорондын функциональ харилцаа; математик загварчлалыг бодит ертөнцийн асуудлыг харах арга, хэрэгсэл болгон ашиглах (жишээлбэл, физик, биологи, нийгэм, эдийн засаг, зан үйлийн шинжлэх ухаанд) болон статистикийн гол суурь ойлголт болох вариаци зэрэг багтана. Асуудал шийдвэрлэлтийн тухайд ПИСА нь гурван төрлийн үйл явцыг тодорхойлдог ба үүнд нөхцөл байдлыг математикийн аргаар томъёолох; математикийн ойлголт, баримт, нотолгоо, үндэслэлийг ашиглах, математикийн үр дүнг тайлбарлах, хэрэглэх, үнэлэх зэрэг багтана.

АГУУЛГЫН МЭДЛЭГ: Математикийн агуулгын ангилалд өөрчлөлт ба холбоо хамаарал, тоо хэмжээ, орон зай ба хэлбэр дүрс, тодорхой бус байдал ба дата өгөгдөл зэрэг багтана. Эдгээр нь тоо тоолол, алгебр, функц, геометр, мэдээлэлтэй ажиллах зэрэг үндэсний математикийн сургалтын хөтөлбөрийн агуулгын хүрээтэй нягт уялдадаг.

ХАМ СЭДЭВ: Сурагчдын гүйцэтгэх даалгаварт хувь хүний амьдралтай холбоотой тодорхой нөхцөл байдал, хам сэдэв өгөгдөнө. Үнэлгээний хүрээнд хувийн, ажил мэргэжлийн, нийгмийн болон шинжлэх ухааны гэсэн дөрвөн хам сэдвийг тодорхойлно.



ПИСА (2022) нь сурагчдын үнэлгээнд нэгэн шинэлэг чиглэл оруулж ирсэн нь бүтээлч сэтгэлгээний сорил юм. Энэхүү сорил нь сурагчдын мэдлэгийг дахин бүтээж чадаж байгаа эсэхийг тодорхойлохоос гадна сурагчид сурсан зүйлсээ хэр сайн өөрийн болгон ашиглах чадвар, тухайн мэдлэгээ сургууль болон сургуулиас гадуурх танил бус орчинд хэрэглэж чадаж байгаа эсэхийг үнэлнэ. Өмнө өгүүлсэнчлэн үнэлгээний энэ

хандлага нь орчин цагт хувь хүн мэддэг зүйлээрээ бус харин мэдлэгээ ашиглан хийж бүтээснээрээ эдийн засгийн системээс ашиг, хувь хүртэх үзэл санаанд суурилж байгаа юм.

Бүтээлч сэтгэлгээ нь анхдагч бөгөөд үр дүнтэй санаа, шинэлэг шийдэл, мэдлэгийн ахиц дэвшил, төсөөлөл, илэрхийлэлд хөтлөх санааг гаргах, үнэлэх, сайжруулахад үр бүтээлтэй оролцох чадварыг хэлнэ

Унших чадвар гэдэг нь сурагчдын зорилгодоо хүрэхийн тулд бичвэр мэдээлэл, текстийг ойлгох, ашиглах, үнэлэх, эргэцүүлэн бодох, ашиглах чадварыг хэлнэ. ПИСА нь сурагчдын унших чадварын гүйцэтгэлийг янз бүрийн асуултуудаар үнэлдэг. Үүнд:



ҮЙЛ ЯВЦ: 15 настай сурагчдын ихэнх нь эзэмшсэн гэж үздэг тул сурагчдын хамгийн энгийн, суурь унших чадварыг үнэлдэггүй. Харин сурагчид бичвэр доторх мэдээллийг ашиглах, хэрэгцээтэй зүйлээ олж авах, холбогдох мэдээллийг хайх, сонгох зэрэг мэдээллийн байршлыг тогтоох ур чадварыг үнэлэхэд чиглэдэг. Мөн сурагчид бичвэрийг ойлгох, шууд утгыг илэрхийлэх, бичвэрийн ерөнхий утга санаа, дүрслэлийг тодорхойлох, бичвэрийн чанар, найдвартай байдал, үнэ цэнийг үнэлэх, агуулга, хэлбэрийг үнэлж, эргэцүүлэн бодох чадвартай эсэхийг үнэлнэ.

БИЧВЭРИЙН ФОРМАТ: ПИСА нь нэг эх сурвалжтай болон олон эх сурвалжтай бичвэрийн аль алийг нь ашигладаг.

Түүнчлэн тогтвортой ба динамик бичвэрүүд, үргэлжилсэн бичвэрүүд (өгүүлбэр, цогцолбороос тогтсон), үргэлжилсэн бус бичвэрүүд (жагсаалт, маягт, график эсвэл диаграмм) болон холимог бичвэрүүдийг багтаана.

НӨХЦӨЛ БАЙДАЛ: Нөхцөл байдал нь бичвэрийн зориулалтаар тодорхойлогддог. Жишээлбэл, хүмүүсийн хувийн хэрэгцээнд зориулсан роман, хувийн захидал эсвэл намтар; нийтийн хэрэгцээнд зориулсан албан баримт бичиг, зарлал, мэргэжлийн хэрэглээнд зориулсан гарын авлага эсвэл тайлан, боловсролын хэрэглээнд зориулсан сурах бичиг эсвэл ажлын хуудас зэрэг байж болно. Зарим сурагчид нэг төрлийн уншлагыг нөгөөгөөсөө илүү сайн гүйцэтгэж чаддаг тул унших чадварын сорилд өргөн хүрээний унших даалгаврыг багтаахыг зорьдог юм.



Байгалийн ухааны мэдлэг, чадвар гэдэг нь тухайн шинжлэх ухаантай холбоотой асуудал, шинжлэх ухааны үзэл баримтлалыг эргэцүүлэн бодох чадвартай байхыг хэлнэ. Шинжлэх ухааны мэдлэгтэй хүн шинжлэх ухаан, технологийн талаар үндэслэлтэй яриа өрнүүлэхэд бэлэн байдаг бөгөөд мөн аливаа үзэгдлийг шинжлэх ухааны үүднээс тайлбарлах, шинжлэх ухааны судалгааг үнэлэх, зохион бүтээх, өгөгдөл, нотолгоог шинжлэх ухааны үүднээс тайлбарлах чадвартай байх шаардлагатай гэж үздэг.

ПИСА-ийн байгалийн ухааны чадварыг үнэлэх сорил нь дараах 3 хүрээг хамаарна.

- 1 **ХАМ СЭДЭВ:** Үүнд шинжлэх ухаан, технологийн талаар тодорхой ойлголттой байхыг шаарддаг хувь хүний, орон нутгийн, үндэсний болон дэлхийн өнөөгийн болон түүхэн асуудлууд хамаарна.
- 2 **МЭДЛЭГ:** Шинжлэх ухааны мэдлэгийн үндэс болсон гол баримт, үзэл баримтлал, тайлбарлах онолуудын тухай ойлголт юм. Ийм мэдлэгт байгаль ертөнц болон технологийн бүтээлийн талаарх мэдлэг (агуулгын мэдлэг), шинжлэх ухаанч санаа хэрхэн бий болдог тухай мэдлэг (үйлийн мэдлэг) болон тэдгээрийг ашиглах үндэслэлийн талаарх ойлголт (хэрэглээний мэдлэг) зэрэг багтана.
- 3 **ЧАДАМЖ:** Юмс үзэгдлийг шинжлэх ухааны үүднээс тайлбарлах, шинжлэх ухааны судалгааг үнэлэх, зохион бүтээх, өгөгдөл, нотлох баримтыг шинжлэх ухааны үүднээс тайлбарлах чадвар юм.



Сорилоос гадна сурагчид болон сургуулиудын хүрээнд нөхцөл байдлыг тодруулахад чиглэсэн асуулга судалгааг зохион байгуулдаг. Энэхүү асуулга нь хоорондоо холбоотой хоёр зорилготой. Эхний зорилго нь танин мэдэхүйн сорилын оноог (боловсролын систем дотор болон боловсролын систем хоорондын) тайлбарлах хам сэдэв, нөхцөл байдлыг тодорхойлох. Хоёрдахь зорилго нь бодлого, судалгаанд тус тусад нь мэдээлэл өгөх танин мэдэхүйн бус, найдвартай, баталгаатай үр дүнг гаргаж авах юм.

Сурагчдаас өөрийнх нь тухай болон сургууль ба гэр бүлийн орчин, суралцахуйн туршлагатай нь холбоотой мэдээллийг цуглуулах зорилготой 35 минутын асуулга судалгаа авдаг. Мөн тухайн улсын хамрагдаж байгаа сургуулийн хам сэдэв, нөхцөл байдалтай холбоотой мэдээлэл цуглуулах зорилгоор сургуулийн удирдлагаас 45 минутад бөглөх асуулга судалгаа авдаг. ПИСА (2022)-ийн тухайд COVID-19 цар тахлаас үүдэлтэй сургууль тасалдалт сурагчдын суралцахуй болон сайн сайхан байдалд үзүүлсэн үр дагавартай холбоотой мэдээлэл цуглуулах зорилгоор “Глобал Хямралын Модуль” нэртэй шинэ асуулгыг нэмж оруулсан байна.

Компьютерт суурилсан сорил нь сурагч бүр 2 цаг гүйцэтгэхээр боловсруулагдсан байдаг бөгөөд сорил нь олон сонголттой хариулт бүхий даалгаврууд болон сурагчдад чөлөөтэй бүтээж, байгуулах боломж олгосон задгай хэлбэрийн даалгавруудаас бүрдсэн байдаг. Сурагч сургалтын хөтөлбөрөөр олгож байгаа шинжлэх ухааны тодорхой мэдлэгийг өдөр тутмын амьдралтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд хэрхэн ашиглаж байгааг нь үнэлэх зорилготойгоор ангилагдсан байдаг.

ПИСА нь зохион байгуулагдах бүртээ сурагч, багш, эцэг эх, сургуулийн талаар өргөн хүрээний өгөгдлийн санг бүрдүүлдэг бөгөөд өгөгдлийн шинжилгээний гарын авлага нь бүх түвшний өгөгдөлд дүн шинжилгээ хийж, үр дүнг гарган авахад зориулагдсан байдаг.

ПИСА нь сурагчдын хүйсийн эрх тэгш байдал, нийгэм-эдийн засгийн орчин, гэртээ ярьдаг хэл, сургуулиудын байршил зэргээс үүдэлтэй танин мэдэхүйн сорилын гүйцэтгэл дэх ялгаанд ач холбогдол өгсөн цуврал тайланг танилцуулдаг. Түүнчлэн ПИСА (2022) нь олон улсын сэдэвчилсэн тайлангуудыг бэлтгэж, дэлхийн дахинд түгээх юм.

МОНГОЛ УЛС ЯАГААД ПИСА (2022)-Д ОРОЛЦСОН БЭ?

Монгол Улс боловсролын чанараа тодорхойлуулж, олон улсад аль түвшинд яваагаа мэдэхийн тулд 2022 онд Сурлагын Амжилтын Олон Улсын үнэлгээ (PISA)-д хамрагдсан. Монгол Улс ПИСА (2022) үнэлгээнд оролцох болсон нэг шалтгаан нь өөрийн улсын сурагчдын гүйцэтгэлийг олон улсын жишиг үзүүлэлтүүд болон бусад ижил төстэй сорилт тулгардаг улс оронтой харьцуулан шинжлэх аргачлалд суралцах, сорилын гүйцэтгэлтэй холбоотой сайжруулах эсвэл арилгах шаардлагатай хүчин зүйлсийг тодорхойлох явдал байв.



Монгол Улс 2030 он гэхэд бүх хүүхэд, залуучуудыг унших чадвар болон математикийн суурь түвшний мэдлэгтэй болгохоор зорилт тавин ажиллаж байна. Энэ нь бүх залуусыг өөрсдийн чадавхийг бүрэн дүүрэн ашиглах, нийгэм, хүрээлэн буй орчинтойгоо нягтран нэгдэж хувь нэмрээ оруулах, сэтгэл хангалуун амьдралаар амьдрахад шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлага, үнэт зүйлийг төлөвшүүлнэ гэсэн үг юм.

Монгол Улсын боловсролын салбарын бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг нь боловсролын үнэлгээний тогтолцоог ПИСА зэрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээнд тулгуурлан бэхжүүлэх билээ. ПИСА-д оролцсоноор Монгол Улсын үндэсний үнэлгээ, үнэлгээ зохион байгуулах үйл явцыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарттай нийцүүлэх боломжтой болж байгаа юм. Түүнчлэн саяхан шинэчлэн баталсан Боловсролын тухай хуульд Монгол улс гурван жил тутам олон улсын үнэлгээнд хамрагдахаар заасан.

Мөн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын чанарыг тодорхой давтамжтайгаар VI, X, XII ангийн сурагчдын мэдлэг, чадвар эзэмшилтээр үнэлж, хэмждэг туршлагатай. Энэхүү үндэсний үнэлгээнд ПИСА-тай адил төстэй гэж үзэж болохоор хэд хэдэн онцлог чанар бий. Нэгдүгээрт, тус үнэлгээнд хамрагдах түүврийг X анги буюу 14-15 насны сурагчдаас хоёр шатлалт түүврийн аргачлалаар сонгодог. Хоёрдугаарт, энэхүү үнэлгээ нь математик, унших чадварын агуулгыг багтаасан сорил болон сурагч, сургуулийн удирдлага, багш нараас ерөнхий мэдээлэл цуглуулах асуулгаас бүрддэг.

МОНГОЛ УЛС ПИСА (2022)-Д ОРОЛЦСОН НЬ

Монгол Улс анх удаа ПИСА (2022)-д оролцсон бөгөөд энэхүү олон улсын үнэлгээнд хамрагдах үйл ажиллагааг Боловсрол, Шинжлэх Ухааны Яам тэргүүлэн ажиллаж, Дэлхийн банк санхүүжүүлж, Боловсролын үнэлгээний төв ПИСА-ийн үндэсний төвийн үүргийг гүйцэтгэж ажилласан юм. Түүнчлэн ПИСА-ийн олон улсын ажиглагч, түншүүд Монгол Улсыг ПИСА (2022)-д оролцоход үнэлгээ, судалгааны удирдлага, зохион байгуулалттай холбоотой бүхий л үйл явцыг дэмжиж ажилласан билээ.



Монгол Улс танин мэдэхүйн гурван үндсэн чиглэлийн сорилоос гадна сурагчдын бүтээлч сэтгэлгээний чадварыг үнэлэх сорилд хамрагдсан юм. Өөр нэг сорилын боломжит хувилбар нь сурагчдын санхүүгийн мэдлэг, чадварыг үнэлэх сорил байсан юм. Хам сэдвийн хүрээний мэдээлэл цуглуулах асуулга судалгаанд

зөвхөн сурагчид болон сургуулиуд хамрагдсан. Монгол Улс ПИСА-д анх удаа оролцохдоо МХХТ-ийн хэрэглээний дадалтай холбоотой асуулга, багшийн асуулга, эцэг эхийн асуулга зэрэг нэмэлт асуулга судалгааг сонгож хамрагдаагүй болно.

ПИСА-ийн техникийн стандартын дагуу түүвэрлэлтийн нарийн журмын дагуу хэрэгжүүлсэн бөгөөд түүвэр нь харьцуулж болохуйц, найдвартай, баталгаат чанарыг хангасан. Боловсролын Статистик Мэдээллийн Системийн баазад тулгуурлан 15 настай 43616 сурагч, 803 сургуулийн бүтэн жагсаалтаас түүврийг сонгосон ба сонгогдсон сургуулиудын 15 настай сурагчдын бүрэн жагсаалтыг сургуулийн удирдлагууд Боловсролын Үнэлгээний Төвд ирүүлсэн билээ.

ПИСА (2022)-ийн техникийн стандартад заасны дагуу түүврийн төлөөлөх чадварыг хангах үүднээс хамрагдах сургууль болон сурагчдын хамгийн бага тоог зааж өгсөн. Боломжит пропорциональ (PPS) түүврийн аргыг ашиглан улсын хэмжээний бүх сургуулиудыг багтаасан жагсаалтаас сургуулиудыг системтэйгээр түүвэрлэн сонгосон. Сургуулиудыг сонгохын өмнө түүвэр сургуулиудыг ил тод болон далд үечлэл бүхий сургуулийн шинж чанарт үндэслэн үечлэл тус бүрт хамаарах тусгай бүлэгт хуваарилсан. Түүвэрлэсэн сургуулиудын бүсчлэл (баруун, зүүн, төв, говь, хангай), байршил (хот - Улаанбаатар, хотын захын - аймгийн төв болон хөдөө - сум), далд үечлэлд сургуулийн өмчийн хэлбэр (улсын ба хувийн) зэргийн холимог байдлаар тодорхой үечлэлд хуваасан болно.

ПИСА-ийн сорил болон асуулгаар мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг 2022 оны 4 дүгээр сарын 5-аас 5 дугаар сарын 15-ны хооронд зохион байгуулсан. Үндэсний хэмжээнд VII-XII ангид суралцаж буй 15 настай нийт 7276 (628 нь Казах сурагч) сурагч унших чадвар, математик, байгалийн ухаан, бүтээлч сэтгэлгээний сорил болон асуулга судалгааг 2 цагийн хугацаанд гүйцэтгэсэн юм.

ДОТУУР БАЙРНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХУЧИН ЧАДЛЫГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА




ЕБС-ийн дотуур байрны орчин, нөхцөл байдал шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудлууд болон нөхцөл байдлыг сайржуулах хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох хэрэгцээ, шаардлага үүсэж байна. Энэ хүрээнд ЕБС-ийн дотуур байрны орчин, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, менежментийг сайжруулах санал, зөвлөмж боловсруулах зорилготой 21 аймгийн төрийн өмчийн 79 сургуулийн дотуур байрнаас дараах зорилтын хүрээнд судалгааг авахаар төлөвлөсөн.

- Дотуур байрны үйлчилгээ үзүүлэх хүчин чадалд шинжилгээ хийх;
- Дотуур байранд амьдардаг хүүхдийн эцэг эхийн хандлага, үүрэг, хариуцлага хамтын ажиллагааг илрүүлэх;
- Дотуур байранд амьдардаг хүүхдийн суралцах болон хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцох оролцоог илрүүлэх;
- Дотуур байрны багшийн албан тушаалын тодорхойлолтод шинжилгээ хийх;
- Дотуур байрны менежмент, түншлэл, хамтын ажиллагаа, хэрэгцээнд шинжилгээ хийх;
- Судалгааны үр дүнд тулгуурлан дотуур байрны менежментийг сайжруулахад санал зөвлөмж боловсруулах;



Судалгаанд 21 аймгийн сонгогдсон сум болон төвийн 79 сургуулийн дотуур байрны сурагч, багш, удирдах ажилтан, байрны ажилтан, эцэг эх асран хамгаалагч, орон нутгийн төрийн захиргааны байгууллагын мэргэжилтэнг судалгаанд хамруулахаар төлөвлөсөн.

Зураг 1. Аймгуудын нийт дотуур байрны тоо болон судалгааны багийн судалгаанд хамруулсан тоо, төрлөөр



Судалгаанд нийт 138 дотуур байр, 7374 сурагч, 391 дотуур байрны багш, 164 дотуур байрны ажилтан, 230 сургуулийн удирдах ажилтан, орон нутгийн ЗДТГ-ын 133 мэргэжилтэн, 1130 эцэг эх асран хамгаалагч оролцлоо.

